

Үндэсний Хэмжээнд Албадан Нүүлгэлтийг Хойшлуулах Талаар Өгөх Ойлголт

Би ажлаа алдсан тул одоо түрээсээ төлж чадахгүй.

Би бас ажлаа алдсан. КОВИД-19-өөс болж миний эргэн тойрны олон хүн түрээсээ төлөхөд хэцүү байгаа.

Холбооны засгийн газар албадан нүүлгэлтийг зогсоосон гэж үнэн үү?

Холбооны засгийн газар Арванхоёрдугаар сарын 31 хүртэл албадан нүүлгэлтийг хойшлуулсан боловч яг баталгаагүй байна. Та мэдэгдлийн хуудсыг бөглөж илгээх шаардлагатай.

Би юу хийх хэрэгтэй вэ?

Өөрийгөө тодорхой шаардлагыг хангаж буйг илэрхийлсэн мэдэгдэлд гарын үсэг зураад, байрны эзэндээ өгөөрэй.

Шаардлага хангахын тулд та дараах зүйлсийг хийх хэрэгтэй:

- ✓ \$99,000-с бага орлоготой эсвэл гэр бүлийн хувьд \$198,000-с бага орлоготой байх
- ✓ Орлоггүй болсны улмаас түрээсээ төлөх боломжгүй болсон
- ✓ Түрээсийн тэтгэмжинд өргөдөл гаргасан ч авч чадаагүй
- ✓ Боломжтой бол түрээсийн төлбөрөө хэсэгчлэн төлөхийг зөвшөөрсөн
- ✓ Хэрэв албадан нүүлгэвэл орон гэргүй болох юм уу эсвэл хэт олон хүнтэй сууцанд орох магадлалтай

Би орлогынхоо талаар ямар нэг бичиг баримт үзүүлэх хэрэгтэй юу?

Та мэдэгдлийн хамт нотолгоо өгөх шаардлагагүй. Гэхдээ байрны эзэн тань асууж магадгүй тул өөртөө байлгах нь зүйтэй.

Та хойшлуулагдсан хугацаанд төлөгдөөгүй түрээсийн төлбөрөө дараа төлөх ёстой юу?

Тийм. Хойшлуулагдсан хугацаанд чадах хэмжээгээрээ төлөөд, дараа нь төлөгдөөгүй үлдсэн бүх төлбөрөө төлөх ёстой.

Тэгвэл би энэ маягтыг яах ёстой вэ?

Мэдэгдлийн маягтанд гарын үсэг зураад, байрны эзэндээ өгөөрэй. Танай өрхөд нэгээс олон насанд хүрсэн хүн байдаг бол хүн бүр өөрийн гэсэн маягтыг бөглөж өгөх ёстой.

Мэдэгдлийг хэрхэн илгээх вэ:

- ✓ Шаардлага хангаж буй эсэхээ мэдэхийн тулд анхааралтай унших
- ✓ Мэдэгдэлд гарын үсэг зурах
- ✓ Байрны эзэндээ э-мэйлээр эсвэл баталгаат шуудангаар илгээх
- ✓ Өөртөө нэг хувь эсвэл зургийг нь авч үлдэх
- ✓ Танай өрхийн насанд хүрсэн хүн бүр өөрийн гэсэн маягтыг бөглөж өгөх ёстой

Бүх зүйлсийг үнэн бөглөнө үү. Уг мэдэгдэл нь хуулийн бичиг баримт юм. Хэрэв та худал мэдээлэл өгвөл, хариуцлага хүлээж болзошгүй.

Нэмэлт эх сурвалжийг харах бол дараахад зочилно уу:

- Орчуулсан Баримтат Хуудас ба Мэдэгдэл
- www.nationalcapacd.org
- www.nhlp.org

Би ямар эрхүүдтэй вэ?

Би АНУ-ын иргэн байх ёстой юу? Энэ нь миний иргэншил хүссэн өргөдөл гаргах боломжид нөлөөлөх үү?

Үгүй, бүх хүмүүс цагаачлалын статусаасаа үл хамааран шаардлага хангаж байгаа. Энэ нь таны иргэншил хүссэн өргөдөл гаргах боломжид нөлөөлөх ёсгүй. Та өмгөөлөгчтэйгээ ярилцах нь зүйтэй.

Хэрэв надад түрээсийн гэрээ байхгүй бол яах вэ? Би шаардлага хангаж чадах болов уу?

Тийм.

Хэрэв манай хот эсвэл мужид өөрийн гэсэн сунгалт хийсэн бол энэ нь хүчинтэй үйлчилсээр байх уу?

Хэрэв танай орон нутагт гаргасан сунгалт хүчтэй бол энэ нь хүчинтэй үйлчилсээр байх болно. Орон нутгийн сунгалтуудын шинэчилсэн жагсаалтыг харах бол мужийн сунгалтуудын энэхүү жагсаалтыг харна уу.

Манай байрны эзэн дүрмийг дагахгүй, манайг албадан нүүлгэх байх гэж би айж байна.

Та нэн даруй орон нутгийн ашгийн бус төрийн бус байгууллагад хандах эсвэл хууль зүйн дэмжлэг авах нь зүйтэй.

Намайг мэдэгдэл өгсөний дараа манай байрны эзэн манайг байрнаас хөөж гаргавал яах вэ?

Энэ нь Халдварт Өвчний Хяналтын Төвөөс (CDC) гаргасан албадан нүүлгэлтийн талаарх шийдвэрийг зөрчсөн үйлдэл болно. Та байрны эзнийхээ талаар мэдэгдэж, хууль зүйн тусламж авахаар хөөцөлдөх нь зүйтэй.

Нэг найз маань албадан нүүлгэлтийн асуудлаар аль хэдийнэ шүүхэд хандсан байгаа. Энэ нь албадан нүүлгэлтийг зогсооход тус болох болов уу?

Албадан нүүлгэлтэнд өртөхөөс сэргийлж мэдэгдлийг нэн даруй бөглөж, илгээж, хууль зүйн дэмжлэг авахаар хөөцөлдөх ёстойг тэдэнд хэлээрэй.

Өөрийн эрхүүдийг мэдэх нь

- ✓ Танай байрны эзэн таныг байрнаас хөөж гаргах эрхгүй.
- ✓ Хэрэв та албадан нүүлгэлтэнд өртөх эрсдэлтэй байгаа бол өмгөөлөгчид хандаарай.
- ✓ Хууль зүйн туслалцаа үзүүлэгчдийн жагсаалтыг авах бол дараахь хаягаар зочилно уу: <https://bit.ly/2xNyl6M>
- ✓ Түрээслэгчдийн холбоодын жагсаалтыг авах бол дараахь хаягаар зочилно уу: <https://bit.ly/2WJb5Kk>
- ✓ Орон нутгийн хуульчдын холбоодын жагсаалтыг авах бол дараахь хаягаар зочилно уу: <https://bit.ly/2KnF0pt>

Тусалцаа үзүүлсэнд баярлалаа!

Зүгээр дээ. Түрээслэгчдийн хувиар бид нэгдэж, бие биендээ туслэх үүрэгтэй!

Түрээслэгчдээ нэгдэгцгээе!

Түрээслэгчид хамтран ажилласнаар илүү хүчирхэг болно!

Өөрийн оршин суугаа барилгадаа түрээслэгчдийн холбоо байгуулах талаар илүү ихийг судлахыг хүсвэл aapineighborhoods.org хаягаар зочлоорой.